

**ОРОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙД***М.Татьяна\**

НҮБ-ын UNIDO байгууллага нь Эдийн засгийн чөлөөт бүсүүдийн /ЭЗЧБ/ үйл ажиллагаанд судалгаа, шинжилгээ хийдэг. Одоогоор дэлхийн 120 оронд 3000 орчим ЭЗЧБ ажиллаж 50 гаруй сая хүнийг ажлын байраар хангаж байна. Эдгээр чөлөөт бүсүүдийн экспортын эргэлт нь 600 тэрбум ам.долларт хүрчээ.

Олон улсын практикт чөлөөт бүсийг *чөлөөт худалдааны* /Нидерланд, Латви, Итали/, *үйлдвэрлэлийн* /Өмнөд Солонгос, Бразил, Мексик/, *техник-технологийн буюу технополис, технопарк болон үйлчилгээний* /Баруун Европ, Зүүн-Өмнөд Ази, Карибын сав газар, Кипр/ гэж 4 ангилдаг. ЭЗЧБ 2 хэлбэрээр байгуулагддаг: нэгд, улсын тусгай хөтөлбөр боловсруулж, төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн төрийн удирдлаган доор явагддаг, харин зарим орнууд хувийн секторын хөрөнгө оруулалт оролцуулдаг /Хятад, Өмнөд Солонгос/, хоёрт, хувийн буюу хосолсон өмчийн хэлбэртэй хуулийн этгээд нь иргэн-эрх зүйн тохиролцооны үндсэн дээр хөрөнгө оруулагчидтай гэрээ байгуулдаг, энэ нь дэлхийд түгээмэл зарчим юм.<sup>1</sup>

Харин Орост анхны ЭЗЧБ-ийг 1990 эхээр байгуулж, 2 дахь үе нь 1990 оны дундуур үргэлжилсэн. Чөлөөт бүс нь эдийн засгийг дээшлүүлэх, өндөр технологийн салбарыг хөгжүүлж, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, зам тээвэр сайжруулах, аялал жуулчлал, амралт-сувиллын газруудыг нээх зорилготой байлаа. 1994 онд БН Ингушет Улс, БН Халимаг Улсад тус тус ЭЗЧБ байгуулагдаж ирээдүйтэй гэж тооцогдож байсан. 1995 онд ЭЗЧБ “Кабардино-Балкария” нээгдсэн.

Гэвч эдгээр бүсүүдэд хөрөнгө оруулагчдад хуулийн таатай орчин бүрдүүлж өгөөгүйгээс болон бусад шалтгаанаар компаниуд нь энд бүртгэгдэж үйл ажиллагаагаа өөр газар явуулж эхэлсэн. Иймээс эдгээр нь зөвхөн оффшор бүс болж хувирсан.

1996 онд Калининград, 1999 онд Магадан мужид эдийн засгийн онцгой бүс /ЭЗОБ/ байгуулах холбооны хууль гарсан. Эдгээр онцгой бүсүүд нь одоо хүртэл үйл ажиллагаагаа явуулдаг боловч хэд хэдэн удаа хууль, эрх зүйн актууд өөрчлөгджээ.

2005 оны 6 дугаар сарын 22-нд №16-ФЗ “ОХУ-ын Эдийн засгийн онцгой бүсүүдийн тухай” холбооны хууль батлагдсан. Тус хууль батлагдсанаар ЭЗЧБ болон ЭЗОБ тухай хуучин хууль, эрх зүйн актууд хүчингүй болсон. Үүнд Калининград, Магадан мужууд хамрагдаагүй болно.

Орос улс нь дэлхийн туршлага судлаж өөрийн ЭЗЧБ-ийн төрийн зохицуулалтыг боловсронгуй болгох, өмнөх амжилтгүй туршлаган дээрээ

\* М.Татьяна - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

үндэслэн өөрчлөлт оруулах шаардлагатай болсон. Дотоод, гадаадын зах зээл дээр үндэсний компаниудын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор шинэ бодлого баримталж эхэлсэн. ЭЗОБ-ийн механизм нь татварын хөнгөлөлт, гаалийн татварын хөнгөлөлт, дэд бүтцийг улсын төсвөөс санхүүжүүлэх, хүнд суртал багасгах нь хөрөнгө оруулагчидад 3 гол чиглэлээр таатай нөхцөл бүрдүүлж өгөх болно. Үүнд Орос улс нь Сингапурын ЭЗОБ-ийн талаар туршлага судалсан байна.<sup>2</sup>

Оросын нутаг дэвсгэр дээр *үйлдвэрлэлийн, техник-технологийн, аялал жуулчлалын* гэсэн 3 төрлийн ЭЗОБ байгуулж болно.

2005 онд ЭЗОБ байгуулах конкурст Оросын субъектууд нь 71 төсөл оруулснаас үйлдвэрлэлийн чиглэлээр 2 нь БН Татарстан Улс, Липецк хотод, мөн “технополис” буюу техник-технологийн 4 ЭЗОБ-үүд Москва / Зеленоград/, Санкт-Петербург, Дубна, Томск хотод тус тус байгуулагдсан.

2006 оны 9-р сард Оросын эдийн засгийн хөгжил болон худалдааны яам нь конкурс<sup>3</sup> зохион байгуулж үүнд 28 бүс оролцсоноос 7 бүсэд Аялал жуулчлал, нөхөн сэргээх эдийн засгийн онцгой бүс байгуулах шийдвэр гаргажээ.

Аялал жуулчлал, нөхөн сэргээх эдийн засгийн онцгой бүсүүд 20 жилийн хугацаатайгаар байгуулагдсан. Үйлдвэрлэлийн болон техник-технологийн бүсүүдээс эдгээр бүс нь хот, хязгаар, муж, районы хэдэн ч захиргааны нэгжийг хамарч болно.

Эрхүү мужид голдуу бизнес, ажил хэргийн аялал жуулчлал, Буриадад- уулын цанан, экологийн аялал, Алтайн хязгаарт – усан, цанын, нөхөн сэргээх, спелеотуризм, Горный Алтайд – уулын цанын, эмчилгээний аяллын чиглэл голлох болно. Краснодар, Калининград мужид далайн эргийн амралт, Ставрополийн хязгаарт – бальнеологийн нөхөн сэргээх эмчилгээ-үйлчилгээ үзүүлнэ. Алтайн хязгаарт “Бирюзовая Катунь”, Эрхүүгийн мужид Большое Голоустное тосгон, Буриадад “Байгал” бүс нь Байгал нуурын эрэгт, Горный Алтайн ЭЗОБ, Краснодарын хязгаарын ЭЗОБ, Ставрополийн хязгаарт – “Кавказские Минеральные Воды”, Калининград мужид – “Куршская коса” тус тус байгуулагдах болсон.

2007 оны 6-р сарын 14-ний өдөр Төрийн Дум нь боомтын ЭЗОБ-ийн тухай шинэ хууль баталж<sup>4</sup> далайн, усан, агаарын гэсэн чиглэлээр шинэ бүсүүдийг байгуулахаар болсон.

Гэвч Орост аялал жуулчлалын бизнес нь бусад орнуудаас хоцордог бөгөөд энэ нь дэд бүтэц, үйлчилгээний түвшин доогуур, өндөр үнэтэй холбоотой. Иймээс татвараас чөлөөлж таатай нөхцөл бүрдүүлэх нь жуулчдыг татаж хөрөнгө оруулагчдад ашигтай бөгөөд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх болно.

Оросын Эдийн засгийн засгийн хөгжил, худалдааны Яамны тооцоогоор, 2026 он хүртэл холбооны төсвөөс 44,5 тэрбум рубль, хувийн сектороос 270 тэрбум рублийн нийт хөрөнгө оруулж, татварын орлогын

хэмжээ нийт 260 тэрбум рубльд хүрнэ. Жуулчдын тоо 3–9,7 сая хүртэл өснө. 2016 онд ҮНБ-д аялал жуулчлалын хувийн жин 2% /одоогоор 0%/ , туслах салбаруудтайгаа нийлээд 9% хүрнэ.

Аялал жуулчлал, нөхөн сэргээх эдийн засгийн онцгой бүс “Бирюзовая Катунь” нь 2007 оны 2 дугаар сарын 3-ны өдөр ОХУ-ын Засгийн газрын 69 тоот тогтоолоор батлагдсан билээ.<sup>5</sup> Тус бүсийн зорилго нь Алтайн хязгаарт амралтын болон нөхөн сэргээх газруудыг байгуулж, байгалийн баялаг, орон нутгийн онцлог илүү ашиглах зорилгоор зохион байгуулалтын, эдийн засгийн орчин бий болгоход оршино. Үүний үр дүнд 1 жилд 1,1 сая жуулчид ирж, шинээр 7 мянган ажлын байр нэмэгдэж, 4,8 тэрбум рублийн хөрөнгө оруулалт хийх юм байна.

БН Алтай Улсад эхний ээлжинд Майминскийн районд<sup>6</sup> “Алтайн хөндий” гэр бүлийн эрүүл мэнд-спортын төв байгуулж 7 зочид буудал, спорт талбай, хиймэл нуур, 3,5 мянган жуулчидыг хүлээн авах боломжтой. Тус бүсэд 2, 4 мян.ажлын байр шинээр бий болно. Төслийг Германы Rolan Berger Strategy Consultants компани гүйцэтгэсэн. Онцгой бүс байгуулахад Алтай улс 2013 он хүртэл нийт 12 тэрбум рублийн хөрөнгө оруулалт, холбооны төсвөөс 4,8 тэрбум рублийн хөрөнгө оруулж, 2009 онд Горно-Алтайск хотын нисэх онцгоцны буудлыг бүрэн засвар хийж дуусгана. 2026 онд жуулчдын тоо 1,5 саяд хүрч, 3000 ажлын байр бий болж, туслах салбартай нийлээд 12 мянгад хүрнэ.

Мөн Байгал нуурын бүсэд Эрхүү муж, Буриад хоёр нь онцгой байр суурь эзэлдэг. Эрхүү мужид анх Листвянка тосгоны Падь Крестовая гэдэг аялал жуулчлалын нэртэй газарт ЭЗОБ нээхээр төлөвлөж, сүүлд Большое Голоустное тосгоныг /Эрхүүгээс 125 км/ сонгосон байна.<sup>7</sup> Листвянка тосгоны төсөл нь бүх талаар давуу талтай байсан боловч, энэ нь Байгал нуурын экологид аюултай гэж үзсэн. Большое Голоустное тосгоны бүсийн барилга нь 2009 онд эхлэж нийт 15 тэрбум рублийн хөрөнгө оруулалт шаардаж 2,56 тэрбум рублийг холбооны төсвөөс гаргах юм байна.<sup>8</sup> Эрхүүгийн бүсийн онцлог нь бизнес, ажил хэргийн амралт (хурал, конференц, үзэсгэлэн зохион байгуулах, хамт олны аялал хийх), усан аялал (Ангар мөрөн, Байгалаар круиз хийх), спортын болон экстрим-аялал, экотуризм, шөнийн цэнгээний газрууд, ресторануудын өндөр үйлчилгээ үзүүлэх болно.

Аялал жуулчлал, нөхөн сэргээх эдийн засгийн онцгой бүс “Байгал” нь 2007 оны 2 дугаар сарын 3-ны өдөр ОХУ-ын Засгийн газрын 68 тоот тушаалаар батлагдсан билээ.<sup>9</sup> Тус онцгой бүсэд аялал жуулчлалын спорт, адал явдлын, жилийн 4 улирлын нөхөн сэргээх зорилготой аялал жуулчлал, танин мэдэхүйн, экотуризмын болон SPA-терапевийн үйлчилгээ явуулж, урьдчилсан судалгаанд шинжээчээр Канадын Ecosign Mountain Resort Planners Ltd. оролцсон байна. “Экосайн” нь уулын цанын амралтын

газруудын шинжилгээ хийдэг дэлхийд нэр хүндтэй компани бөгөөд нийт 32 оронд 250 төсөл боловсруулжээ.

Тус бүсийн газрын нийт хэмжээ нь 700 кв.метр бөгөөд өмнөд, төв, хойд 3 хэсгээс бүрдэж энд нийт “5 одтой” өндөр зэрэглэлийн 14 зочид буудал, “4 одтой” – 16, “3 одтой” – 24, мөн “хаус” хэлбэрийн мянгаад буудал баригдах болно. Үүний зорилго нь олон улсын аялал жуулчлалын таатай нөхцөл бүрдүүлэхээс гадна, шинээр ажлын байр бий болгох, гадаадын хөрөнгө оруулалт татах, Буриадын байгалийн баялаг ашиглан эдийн засгийн шинэ боломж нээх, Байгал нуурыг Оросын болон гадаадын жуулчдал нээж өгөх нөхцөл бүрдүүлснээр Буриадын эдийн засаг сайжирч, хүн амын амьжиргааны түвшин, чанарыг дээшлүүлэх, тогтвортой хөгжлийг хурдасгах болно гэж үзэж байна. Тус газар аялал жуулчлал хөгжиснөөр 1 жилд 1 сая жуулчид ирж, шинээр 34 мянган ажлын байр бий болж, 38 тэрбум рублийн хэмжээний хөрөнгө оруулалт янз бүрийн салбарт хийх юм байна.<sup>10</sup>

Мөн Орост “Алтайн хөндий” болон “Бирюзовая Катунь”, Эрхүүгийн болон Буриадын бүсүүдийн газар зүйн ойр байршил дээр нь үндэслэн хооронд нь холбож аялал жуулчлалын кластер *cluster*<sup>11</sup> байгуулах боломжтой гэж үзэж байна.

Орос улс нь хил орчмын болон хөгжил буурай бүсүүдэд ЭЗОБ байгуулах нь эдгээрийн *хөгжлийн туйл* болно гэж үздэг. Үүнээс харахад, онцгой 7 бүсээс 4 нь Монголтой хил залгаа, хамтын ажиллагааны олон жилийн туршлагатай субъектууд бөгөөд Монголын хувьд бүс нутгийн хөгжлийн шинэ нэн таатай нөхцөл нээгдэж байна хэлж болно.

Монгол Улсын хувьд, хөрш орнуудын эдийн засгийн бүс нутгийн бодлого нь түүний эдийн засгийн хөгжилд нөлөө үзүүлсээр ирлээ. Ирээдүйд Оросын том кластеруудын ойр байршил нь Монголд аялал жуулчлал хөгжүүлэх улам таатай нөхцөл бүрдүүлж, Байгал нуур, Хөвсгөл нуурыг холбосон аялал жуулчлалын хамтарсан төсөлд Монголын тал өргөнөөр оролцох, Оросын жишгээр Хөвсгөл нуур болон бусад газруудад *хөгжлийн туйл* болох өөрийн ЭЗОБ нээх боломж гарч байна. Үүнд Монголын олон улсын аялал жуулчлалын салбарын олон жилийн туршлага хөрш зэргэлдээ Оросын эдийн засгийн онцгой бүсүүдийг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулах нь гарцаагүй. Нөгөө талаас, Монголд олон улсын аялал жуулчлалын кластерын туршлага судлах хэрэгтэй.

Аялал жуулчлалын салбараас гадна Эрхүү, Буриад, Алтай, Алтайн хязгаарын нутаг дэвсгэр дээр мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах, Монголын ноос, ноосон бүтээгдэхүүний үйлдвэр, ногооны аж ахуй, хөдөө аж ахуй болон эдийн засгийн бүхий л салбарт хамтран ажиллах боломж нээгдэж байна.

**Ашигласан материал:**

1. В.В.Петрунин. Советник правового департамента Правительства РФ, государственный советник РФ 3 класса. Источник - “Финансовые и бухгалтерские консультации”, 2007, N7. <http://www.rosez.ru/>
2. <http://echo.msk.ru/interview/44974/index.shtml> Радиостанция «Эхо Москвы»: Интервью, 21.07.2006. Ю Глава Федерального агентства по управлению особыми экономическими зонами
3. [http://www.rosez.ru/law/konkurs\\_trz.html](http://www.rosez.ru/law/konkurs_trz.html) Информационное сообщение о проведении конкурса по отбору заявок на создание особых экономических зон туристско-рекреационного типа. Утверждено П
4. <http://www.kodeks-luks.ru/ciws/> N424303-4 “О внесении изменений в Федеральный закон “Об особых экономических зонах в Российской Федерации и другие нормативные правовые акты Российской Федерации”.
5. <http://www.biryuzovayakatun.ru/info/?info=1> Особая экономическая зона “Бирюзовая Катунь”
6. <http://www.vsesmi.ru/news/506342/1150857/> Михаил Фрадков подписал постановление о создании туристско-рекреационной зоны в Республике Алтай. 07.02.2007
7. <http://tayga.info/news/13422/> Иркутская область подготовилась к открытию особой экономической зоны. Иркутск, Экономика, 27 сентября 2006.
8. <http://www.irk.ru/news/20061208/zone.html> В Иркутской области будет создана особая экономическая зона туристского типа.
9. <http://www.baikalzone.ru/info/?info=1> Особая экономическая зона “Байкал”
10. Мөн тэнд.
11. Международная научно-практическая конференция “Рекреационное природопользование, туризм и устойчивое развитие регионов”. Барнаул – Горно-Алтайск 23-26 октября 2007 года. А.Александрова. МГУ им.Ломоносова.